



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/95

Бат-Өлзий сум


Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд өвөлжилт хүндэрсний улмаас Сэлэнгэ аймгаас улсын Онцгой комиссоос олгосон 500 шуудай улаан буудай ачих шатахууны зардалд 2,294,000 (хоёр сая хоёр зуун ерэн дөрвөн мянга) төгрөг, “Хайр 2000” төслөөс малчдад үнэгүй олгож буй гурил, будааг хүргэх шатахууны зардалд 250,000 (хоёр зуун тавин мянга), Сэг зэм устгах тээвэрлэх шатахууны зардалд 3,165,800 (гурван сая нэг зуун жаран таван мянга найман зуу) нийт 5,709,800 (таван сая долоон зуун есөн мянга найман зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 5,709,800 (таван сая долоон зуун есөн мянга найман зуу) төгрөгийг сумын Эрсдэлээс хамгаалах сангаас зарцуулахыг сумын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С. АМГАЛАН